


**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА,
ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧИГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын лаборатори сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль болон гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургуулиас бусад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах асуудлаар иргэн, аж ахуй нэгж байгууллагууд Нийслэлийн Боловсролын газарт хандана. Дээрх сургууль, цэцэрлэгт Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д зааснаар аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах хүсэлт гаргагч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-21.1.8-д заасан баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ.

**ХЭН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА /сургууль, цэцэрлэг/
БАЙГУУЛЖ БОЛОХ ВЭ?**

Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, багшлах боловсон хүчнээр хангагдсан нөхцөлд өмчийн аль ч хэлбэрт үндэслэн байгуулж болно.



Сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр нь төрийн болон орон нутгийн өмчийн сургалтын байгууллагын хувьд үүсгэн байгуулагчийн тушаал, захирамж, өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагын хувьд үүсгэн байгуулагчийн хурлын шийдвэр, гэрээ, албан бичгийн хамт байна.

Сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл хүсэгч нь:

ХУУЛИЙН ЭТГЭЭД:

1. Үүсгэн байгуулагчийн хурлын шийдвэр
2. Хамтран ажиллах гэрээ

Үүсгэн байгуулагч компани, цэцэрлэгийн захиргаа хоорондын хамтран ажиллах гэрээ байна.
3. Албан бичиг

ИРГЭН:

1. Өргөдөл

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөлд өргөдөл гаргагч Боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг бүрэн хангаж байгааг илэрхийлж гарын үсэг зурах ба нэр, албан тушаал, холбоо барих утас, иргэний үнэмлэх эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаар, оршин суугаа газрын хаяг, он, сар, өдрийг заавал бичнэ.



Хэд хэдэн хуулийн этгээд, иргэн сургалтын байгууллагыг хамтран үүсгэн байгуулах тохиолдолд талууд гэрээ байгуулж баталгаажуулна. Гэрээнд үүсгэн байгуулагчийн нийлүүлэх хөрөнгө, эзэмших хувь хэмжээ, эрх үүрэг, хариуцлага, бусдад эрх шилжүүлэх, үүсгэн байгуулагчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, сургалтын байгууллагыг татан буулгах зэрэг асуудлыг тусгасан байна.

Сургалтын байгууллагын үүсгэн байгуулагчийн мэдээллийг дараах байдлаар хүснэгтээр гаргана.

1. Овог нэр
2. Хүйс
3. Төрсөн он
4. Иргэншил
5. Иргэний үнэмлэх түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн дугаар
6. Төгссөн сургууль (он, хаана)
7. Үндсэн мэргэжил
8. Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
9. Сургалтын байгууллагад хүлээх үүрэг (хариуцах чиглэл)
10. Харилцах утас, факс, емэйл

Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар байна.

Сургалтын байгууллагын дүрэмд байгууллагын зорилго, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, багш, суралцагчдын эрх ашгийг хамгаалах, хангах, бусад байгууллага, иргэдтэй харилцах зарчим, санхүүжилтийн эх үүсвэр болон тэдгээрт холбогдох асуудлын хүрээнд сургалтын байгууллагын дагаж мөрдөх хэм хэмжээг тодорхой тусгана.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх” гэж зааснаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт авсан байна.

ЦЭЦЭРЛЭГ БАЙГУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ТООЦОО

БҮХИЙ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын байгууллага байгуулах хэрэгцээ, шаардлага:

1.
2.ГМ.

№	Чиглэл	Мэдээлэл
1	Байгууллагын чиг үүрэг	
2	Цэцэрлэгийн хэв шинж	
3	Сургалтын хэлбэр	
4	Эзэмшүүлэх боловсролын түвшин	

5	Цэцэрлэгийн хүчин чадал	
6	Бүлгийн тоо	
7	Багшлах боловсон хүчин	
8	Нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо	
9	Нэг багшид ногдох хүүхдмийн тоо	

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА
/ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬ/-ЫН НЭР СОНГОХ**

Нийслэлийн Засаг даргын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох тухай захирамжид боловсролын сургалтын байгууллагын оноосон нэр заавал бичигддэг тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасан шаардлагыг хангасан нэрийг сонгоно. Иймд [Улсын бүртгэлийн байгууллагаас](#) боловсрол сургалтын байгууллагынхаа [нэрийн баталгаажилтын хуудас](#) авч, бичиг баримтад хавсаргана.

**СУРГАЛТЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ БОЛОН ЦААШИД БҮРЭН ХҮЧИН ЧАДЛААРАА
АЖИЛЛАХ ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ТООНЫ ТӨЛӨВ**

Тухайн хорооны 1-6 хүртэл насны сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргана. Үүнд тулгуурлан бүлгийн зохион байгуулалтыг хийнэ.

ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙГ ГУРВАН ЖИЛЭЭР ТООЦСОН СУДАЛГАА

СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Нэг хичээлийн жилд зарцуулагдах нийт зардал	Нэг хүүхдэд хичээлийн жилд зарцуулах зардлын хэмжээ	Нэг хүүхдэд сард зарцуулах зардлын хэмжээ
Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг хасаж тооцсоноор		
Нэг хүүхдэд ногдох төлбөрийн хэмжээ:		

**СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЛД ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ**

№	Хөрөнгийн төрөл	Өртөг
1	Биет	
2	Мөнгөн	
Нийт дүрмийн сангийн хэмжээ:		

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ

Өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллага хүчин төгөлдөр мөрдөж байгаа Монгол Улсын боловсролын стандарт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын талаар баримтлах бодлого, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг сургалтад заавал мөрдөх ба тэдгээрт нийцүүлж сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан байна.

Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулахдаа дараах эрхзүйн баримт бичгийг үндэслэл болгоно.

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/301 дугаар тушаал, “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай”
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/240 дүгээр тушаал, “Бага боловсролын сургалтын төлөвлөгөө”, “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2016 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/302 дугаар тушаал /Суурь боловсрол/
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/453 дугаар тушаал

БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТАН,

БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

№	Багшийн овог нэр	Хүйс	Төрсөн он	Төгссөн сургууль	Мэргэжлийн зэрэг (зөвлөх, тэргүүлэх, заах аргач)	Багшлах эрхийн үнэмлэхийн дугаар	Ажлын туршлага	Ажил ласан жил	Ямар албан тушаалд ажиллах	Үндсэн багш эсэх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

Боловсрол сургалтын байгууллагын удирдах ажилтан, багшлах боловсон хүчний мэдээллийг дээрх хүснэгтээр гаргаж холбогдох бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

- Багш, удирдах ажилтны диплом
- Мэргэжлийн зэргийн үнэмлэх
- Багшлах эрхийн үнэмлэх
- Нийгмийн даатгалын дэвтэр болон даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Төрийн албан хаагчийн анкет маягт 1 –ийг бөглөсөн байна.

Сургалтын байгууллага нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ХҮЧИН ЧАДАЛ ТҮҮНИЙ БАТАЛГАА

Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгааны тухай танилцуулгад хөрөнгийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлсэн, дүрмийн сан болон анхны хөрөнгө оруулалт, сургалтын төлбөрийн хэмжээ, түүнийг тогтоосон үндэслэл, нийт орлогод сургалтын төлбөрийн орлогын эзлэх хувийн талаар тусгаж дараах зүйлийг хавсаргана.

- 1/Үүсгэн байгуулагчийн санхүүгийн чадавхийг харуулсан нотлох баримт;
- 2/Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн өмчлөгч болохыг нотлох гэрчилгээ. Хэрэв аж ахуйн нэгж байгууллага сургалтын үйл ажиллагаа эрхлэх бол тухайн сургалтын байгууллагын бие даасан хуулийн этгээд болохыг санхүүгийн хувьд тодорхойлох эхлэлтийн баланс;
- 3/Үүсгэн байгуулагч нэг буюу түүнээс дээш тохиолдолд сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө (биет болон мөнгөн)-ийн баталгааг үүсгэн байгуулагчийн хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан байна. Хэрэв нэг гишүүнтэй этгээд үүсгэн байгуулагч бол шилжүүлэх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулсан байна ;
- 4/ Эдийн засаг, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлсэн үндсэн хөрөнгийн бүртгэлийн задаргааг жагсаалтаар гаргасан байна.
- 5/ Харъяа татварын байгууллагад өр төлбөргүй, үл хөдлөх хөрөнгийн барьцаагүй болохыг нотолсон бүртгэх байгууллагын тодорхойлолт, Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан тэмдэгтийн хураамж, гэрчилгээний хураамж төлсөн баримт, харилцах банкны нэр, дансны дугаар, улсын бүртгэлд мэдүүлсэн харилцагч банкнаас олгосон өр, зээлийн талаархи тодорхойлолт;

ЦЭЦЭРЛЭГИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Сургалтын хэрэглэгдэхүүн, ном гарын авлагыг номын сангийн анхан шатны данс бүртгэл, үндсэн хөрөнгөд бүртгэсэн бүртгэлийн холбогдох баримт бичиг;

Тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн нь хүүхдийн эрүүл мэнд, бие махбодод сөрөг нөлөө үзүүлэхгүй болох талаар мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт

Цэцэрлэгийн гадаад орчныг сургалт, танин мэдэхүйн чиглэлээр тохижуулсан зураг

БАТАЛГАА ГАРГАХ ТУХАЙ

Сургалтын байгууллагын үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон Боловсролын тухай хуульд заасан үндэслэлээр түдгэлзүүлэх, татан буулгах тохиолдолд багш, суралцагчдын эрх ашгийг хэрхэн хамгаалах, учирсан хохирол (багшийн цалин хөлс, сурагчийн хувийн хэрэг, боловсролын баримт бичиг, сургалтын төлбөрийг буцаан олгох эсэх)-ыг барагдуулах тухай баталгаа

Өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаанд Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсгээр хориглосон сургалт, үйл ажиллагааг ямарваа хэлбэрээр зохион байгуулахгүй болохыг нотолсон баталгаа, албан бичиг үйлдэж, баталгаажуулсан байна.

СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Сургалтын байгууллагын барилга, байгууламжийн хүчин чадлын мэдээллийг энэхүү шаардлагын хавсралтаар баталсан маягт №2-ын дагуу гаргана.

	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Нэг хүнд ногдох талбай (м2)
1	Барилгын хүчин чадал /суудал/		
2	Барилгын нийт талбай м2		
3. Нийт өрөө, танхим			
Үүнээс:	Хичээллэх анги, танхим		
	Кабинет лаборатори		
	Номын сан		
	Уншлагын танхим		
	Биеийн тамирын зал		
	Биеийн тамирын хувцасны өрөө		
	Захиргаа, аж ахуйн өрөө		
	Эмнэлгийн үйлчилгээний өрөө		
	Унтлагын өрөө /цэцэрлэг/		
	Бие засах газар		
	Цайны газар		

Хянасан:()

Судалгаа гаргасан: ()

!!!

ЗОРИУЛАЛТЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ:

Зориулалтын барилга байгууламж нь үүсгэн байгуулагчийн эзэмшлийн өмч болохыг нотлох үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

ЗОРИУЛАЛТЫН БУС БАРИЛГА БАЙГУУЛАМЖ:

Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын бус барилга байгууламжид явуулах тохиолдолд барилгын үндсэн хийц, бүтээцэд нөлөөлөхгүйгээр сургалтын үйл ажиллагаа явуулах шаардлагад тохируулан эзлэхүүн төлөвлөлтийг өөрчлөх ажлын зураг, төслийг холбогдох мэргэжлийн байгууллагаар боловсруулж, баталгаажуулсан байна.

Хэрэв түрээсийн байр ашиглах бол “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай” хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу бүртгэгдсэн түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хэрэв зээлийн байр ашиглах бол “Иргэний хууль”-ийн дагуу байгуулсан зээлийн гэрээний хуулбарыг ирүүлнэ.

Сургалтын барилга байгууламжийг Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага” MNS 6558:2015, стандартын дагуу тохижуулсан байх шаардлагатай.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн тоглоомын талбай болон ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын заалтай байх

ХАВСРАЛТААР ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ ИРҮҮЛНЭ.

1. Боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөө
2. Боловсролын сургалтын байгууллагын дотоод журам
3. Ажлын байрны тодорхойлолтууд (Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 10-р сарын 05-ны өдрийн 351-р тушаалын 4-р хавсралт)
4. Багш, ажилчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээ
5. Эцэг эх, суралцагчтай байгуулах гэрээ (Цэцэрлэгийн захиргаа, багш, эцэг эх, асран хамгаалагч хоорондын гурвалсан гэрээ

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх холбогдох баримт бичиг, маягтад түүнийг боловсруулсан, зөвшөөрсөн, хянасан ажилтан заавал гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна.

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын хуудас бүрийг дугаарлан баталгаажуулж, хоёр хувь үйлдсэн байна.

-----oo0oo-----

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА,
ДУНД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ /хураангуйлсан/

1. Улсын бүртгэлийн газраас нэрийн баталгаажилтын хуудас
2. Албан бичиг / өргөдөл
3. Үүсгэн байгуулагчийн хурлын шийдвэр /хуулийн этгээдийн хувьд/
4. Хамтран ажиллах гэрээ /хуулийн этгээдийн хувьд/
5. Үүсгэн байгуулагчийн мэдээлэл
6. Сургалтын байгууллагын дүрэм
7. Сургалтын байгууллага байгуулах үндэслэл тооцоо бүхий танилцуулга /хүснэгтээр/
8. Бүрэн хүчин чадлаараа ажиллах хүртэлх хүүхдийн тооны төлөв
9. Төсвийн төсөөлөл
10. Сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлсэн хөрөнгийн жагсаалт
11. Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө
12. Удирдах ажилтан багшлах боловсон хүчний бүрэлдэхүүн /багш нарын диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар/
13. Барилга байгууламжийн талаарх мэдээлэл /хүснэгтээр/
14. Үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших гэрчилгээ нотариат хийлгэсэн байх / хэрэв түрээсийн гэрээгээр ашиглах бол нотариатаар гэрчлүүлж улсын бүртгэлд бүртгэгдсэн гэрээ байна
15. Барилга байгууламжийн план зураг
16. Цагдаагийн байгууллагын тодорхойлолт /дүрс бичлэгийн камер, техник хэрэгсэл суурилуулсан эсэх, шаардлага хангасан тухай/
17. Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал түүний баталгаа
18. Цэцэрлэгийн эд хөрөнгийн жагсаалт
19. Хуульд заасан үндэслэлээр түтгэлзүүлэх, татан буулгах тохиолдолд учрах хохирлыг бүрэн барагдуулах талаарх баталгаа
20. Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсгээр хориглосон сургалт явуулах үндэслэлгүй талаарх баталгаа
21. Боловсролын сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөө
22. Боловсролын сургалтын байгууллагын дотоод журам
23. Ажлын байрны тодорхойлолтууд
24. Багш ажилчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээ
25. Суралцагч, эцэг эхтэй байгуулах гэрээ
26. Сургалтын зориулалтаар тохижуулсан бодит зураг

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ОРЧИН

MNS 6558 :2015 стандартаас

Гадна орчин болон барилга байгууламж

- 1,6 метрээс багагүй өндөртэй хашаатай байна
- Гэрэлтүүлэг, камертай байх
- Тоглоомын болон биеийн тамирын талбай/сүүдрэвчтэй байна/
- Цэцэрлэгийн нэр хаягийг стандартын дагуу Монгол хэлээр бичсэн байна
- Орох гарах хаалганы довжоог хальтиргаанаас хамгаалсан байх, хаалганы гадна орчинд цардсан байх
- Орон сууцны 1 давхарт байрладаг бол орцноос тусдаа хаалгатай байна
- Галын болон аюулгүй байдлын дохиоллын системтэй байна
- Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байх, агааржуулалтын системтэй байна
- Шатны бариул 1,2 метрээс багагүй өндөртэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шатны хашлаганы өндөр 15,-1,8 м өндөр
- Цэцэрлэгийн анги танхим өрөөний байршлыг харуулсан план зургийг хаалганы дэргэд байрлуулах

Бүлгийн өрөө

- Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл байх
- Хана, шалны дэвсгэр хэт эрээн бус, цайвар өнгөтэй байх
- Бүлэг бүрт аюулгүйн гарцын зураглалыг харааны түвшинд байрлуулах
- Агаарын солилцоо хангалттай явагдах нөхцөлтэй, ердийн болон механик агааржуулалтын төхөөрөмжөөр хангагдсан байх
- Өрөөний хананд 0,8-1,0 метрт дулаан хэмжигч байршуулсан байх
- Анги танхимын тавилга хэрэгслийг хөдөлгөөнгүй тогтвортой байрлуулж, аюулгүй байдлыг хангасан байх
- Хурц үзүүр ирмэгтэй, шил төмрөөр хийсэн тавилга хэрэгсэл ашиглахгүй байх

Ариун цэврийн өрөө

- Агааржуулалтын системтэй, салхивч нь дээд талдаа байрласан байх
- Цахилгааны холболт нь далд байх
- Шал хальтардаггүй материалаар хийгдсэн, 1 түвшинд байх
- Суултуурууд хоорондоо тусгаарлагчтай, хүүхэд унахаас сэргийлсэн бариултай байх
- Угаалгын өрөө нь бохир цэвэр хэрэгслийг хадгалах тусгай тавиур, шүүгээтэй байх
- Угаалтуурын өндөр 50-60 см, хоорондын зай 50-50см, суултуурын өндөр 20-28 см, урт нь 55 см,

Уншиж, судлах материал:

- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Монгол Улсын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандарт.Ерөнхий шаардлага” MNS 6558 : 2015
- "Барилгын норм ба дүрэм" (БНбД II-66-88, БНбД II-76-79)
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 353 дугаар тушаал